



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/376

Улаанбаатар хот

Улаанбурхан өвчний эсрэг  
дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.4, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 28 дугаар тушаал, Улсын онцгой комиссын 2025 оны 01 дүгээр тогтоол, 2025 оны 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээн дэх Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлж, долоо хоног тутамд журмын дагуу эрсдэлийн үнэлгээ хийж, хүн амын дархлаажуулалтад хамрагдалтыг 95 ба түүнээс дээш хувьд хүргэх чиглэлээр төлөвлөгөөт арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсүгэй.

2. Улаанбурхан өвчний дархлаажуулалтад дүүргийн 0-15 хүртэлх насны хүүхдүүдийг нөхөн хамруулж, дархлаажуулалтын ажлын явцын мэдээллийг 7 хоног тутамд танилцуулж ажиллахыг Чингэлтэй нэгдсэн эмнэлэг (Х.Ганцэцэг)-т, Ерөнхий боловсролын, сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг дархлаажуулалтад хамруулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргийн Боловсролын хэлтэс (Ц.Цолмонбаатар)-т, Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан хийгдэх дархлаажуулалтын ажилд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Л.Баярмаа), 1-24 дүгээр хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ



1525011147